

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес издателя: 191186,
Санкт-Петербург, д. 18.
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXV • 2022 • № 4

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Посвящается 150-летию со дня рождения
русско-польского монголоведа
Владислава Людвиговича Котвича (1872–1944)

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,
доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук
(Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор
РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, про-
фессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 12.12.2022

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvov.ru

ISSN 2311-5939

DOI 10.25882/jrj4-8w22

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2022

© Коллектив авторов, 2022

В НОМЕРЕ:

Вл. Л. Котвич (1872–1944) — российский Ученый и Учитель (<i>И. В. Кульганек</i>)	5
ЛИНГВИСТИКА	11
Мөнхбатын ОЧИРЦЭНД. Дархад аман аялгууны эгшиг авиалбарын тогтолцоо (Система гласных фонем дархатского диалекта)	11
ЛИТЕРАТУРОВЕДЕНИЕ И ТЕКСТОЛОГИЯ	21
Чулууны ЗАЯАСҮРЭН. Гэрийн ерөөлийн бичмэл судруудын уран сайхны онцлог (Художественные особенности сутры благопожеланий дому)	21
Дашнямын МӨНХ-ОТГОН. Исследование версии на тибетском языке дидактических стихов Равджи «Бумажная птица»	28
ФОЛЬКЛОР И ЭТНОГРАФИЯ	37
Г. А. Дорджиева, С. В. Подрезова. Ранние записи калмыцкой музыки в Фонограммархиве Пушкинского Дома: экспедиция А.В. Бурдукова и Ф.Н. Гоухберг 1939 года	37
НАУЧНАЯ ЖИЗНЬ	50
М. В. Федорова. Выставка «Народы Великой степи: буряты, калмыки» в Российском этнографическом музее	50
О. В. Жербанова. «Времен связующая нить»: выставки живописи, графики и каллиграфии. Санкт-Петербург. 12–30 июня 2022 г.	57
Н. В. Ямпольская. Рец. на: Инеднты калмыцкого фольклора из архива И. И. Попова: несказочная проза и малые жанры / сост., перевод Б. Б. Горяева, С. В. Мирзаева, Д. В. Убушиева. — Элиста: КалмНЦ РАН, 2021	63
И. В. Кульганек. Новые книги по монголоведению	68

Мөнхбатын ОЧИРЦЭНД

ДАРХАД АМАН АЯЛГУУНЫ ЭГШИГ АВИАЛБАРЫН ТОГТОЛЦОО

Дархадууд Хөвсгөл аймгийн хойд хязгаар Хөвсгөл нуур орчим Рэнчинлхүмбэ, Цагааннуур, Улаан-Уул, Баянзүрх сумдын нутгаар амьдардаг, монголын уламжлалт бөө мөргөлийн соёлыг хадгалж үлдсэн өвөрмөц угсаатны бүлэг юм. Дархад бол Монгол нутгийн умард хэсэгт байсан ойн иргэдийн залгамж бөгөөд монгол, түрэг овог аймгаас бүрэлджээ. Бид дархад аман аялгууны эгшиг авиалбар түүний бүрэлдэхүүнийг хос эсрэгцлийн зарчмаар гаргахыг зорив.

Түлхүүр үг: Нутгийн аялгуу, дархад аман аялгуу, эгшиг авиалбар, хосын зарчим, утга ялгах

Зохиогчийн тухай: Мөнхбатын ОЧИРЦЭНД, юниорийн эрдэм шинжилгээний жилтан, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн (Монгол улс, Улаанбаатар хот) (ochirtsend_m@mas.ac.mn).

© ИВР РАН, 2022

© Очирцэнд М., 2022

Г. Д. Санжеев, 1927 онд дархад нутгаар хэл, аман зохиолын судалгаа хийж, “Дархадууд”, “Дархад аялгуу аман зохиол” гэдэг хоёр ном хэвлүүлсэн ба дархад аялгууны тухай монголч эрдэмтэд янз бүрээр тайбарлан бичжээ. Я. П. Шишмарев “Дархад аялгууг хорь буриад аялгуунд ойрхон”, Б. Я. Долбежев “Дархад хэл манай Эрхүүгийн буриад хэлтэй ойр бөгөөд халимаг аялгууны шинжийг хадгалсан зүйл ч бий” гэжээ. А. Д. Руднеев дархадуудыг буриад аялгуунаас дөрвөд аялгуунд шилжиж байгаа завсрын аман аялгуутан, А. В. Бурдуков, ойрад аялгуунд илүү ойрхон, Г. Д. Санжеев ойрад, буриад аялгууны завсрын шинжийг хадгалсан гэх мэтээр тодорхойлсон байна. Бид дархад аман аялгууны ангиллын асуудлыг энэ судалгаанд голчлон үзэлгүйгээр эгшиг авианы бүрэлдэхүүн хэсгийг тодруулахад анхаарлаа хандуулсан билээ. Д. Төмөртоогоо “Дархад аман аялгууны урт эгшиг, тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл”, “Дархад аман аялгуу” зэрэг өгүүлэл бичсэн бөгөөд дархад аман аялгуу нь ерөнхий шинжээрээ Халх, Ойрад, Буриад аялгууны дундын байдалтай юм [Хэл зохиол, 1967. Х. 196] гэжээ. Ц. Шархүү “Дархад аман аялгууны авиа зүй” дипломын ажил, Ж.Санжаа “Дархад аялгууны урт эгшигийг авиалбарын

түвшинд судалсан нь” өгүүлэл, Д. Туяа “Дархад аман аялгууны онцлог” зэрэг бүтээл дархад аялгуу судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Э.Баярчимэг “Өдгөө монгол хэлний олон нутгийн аялгуу нь төв аялгуундаа ойртсоор байгаа ба энэ нь хурдсах тусам аялгуу, аман аялгуу, салбар аман аялгууны авиа зүй, хэл зүй, үгсийн сангийн өвөрмөц ялгаа нь арилсаар байна. Тиймээс энэ бүгдийг хадгалан үлдээхийн тулд өмнөх үеийн судлаачдын судалсан бүтээлийг хойч үедээ сурталчлан таниулах, үргэлжлүүлэн судлах хэрэгтэй [Баярчимэг, 2018. Х. 51] хэмээн үзсэн нь нэн чухал санаа юм.

Дархад аман аялгууг нэлээд хожуу судалж эхэлсэн манай улсад 1962 онд профессор Б. Ринчений удирдсан шинжилгээний анги Хөвсгөл, Булган аймагт ажиллаж, дархад, урианхай, буриадын аман аялгуу судлах материал цуглуулснаар дархад аялгууны судалгааны эхлэлийг тавьсан байна.

Бид дархад аман аялгууны авиалбар зүйн нэгж болох эгшиг авианы утга ялгах ба үл ялгах шинжийн тухайд авч үзэж, авиалбар зүйн үндсэн ойлголт түүний судлах зүйл, хэлэхийн явцад дархад аман аялгууны эгшиг авиа нэг бүрийн үгийн бүтцэд гүйцэтгэх үүргийг тодорхойлох шаардлагатай болж байна.

Энэхүү судалгааг хийхдээ эх хэрэглэгдэхүүн болгож Г. Д. Санжеев. Дархатский говор и фольклор. Л., 1931., Д.Туяагийн “Дархадын салбар аман аялгууны онцлог” (2011) докторын ажлын хавсралт хэсгийн аман аялгууны тольд орсон үгсээс түүвэрлэн авч эх хэрэглэгдэхүүн болгон ашигласнаас гадна Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын дархад М. Ганзориг, нас 30. 2021 оны 4-р сарын 3-ны өдөр уулзан ярилцаж тэмдэглэж авав. Мөн Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын дархад Шарнууд овогтой А. Ням-Эрдэнэ нас 27 Улаанбаатар хотод хувийн аж ахуй эрхэлдэг хотод орж ирээд 4 жил болж байгаа. Эхнэр хүүхдийн хамт амьдардаг. 2021 оны 4 дүгээр сарын 02-нд уулзан ярилцаж, асуулгийн аргыг хэрэглэн тэмдэглэл хөтлөсөн ба өмнөх судлаачдын бүтээлд ашигласан үгсийг түүвэрлэн авч лавшруулан тодруулах зорилгоор ашиглав.

2022 оны 3 сарын 4-ний өдөр Цахим суврага төрийн бус байгууллагын хамт олонтой Хатгалаас гаран Ханх сумаар дамжин өнгөрч, Ренчинлхүмбэ сумын 3-р баг буюу Ходон багийн Нуруу шарын нүүдлийг уламжлан хадгалагч, дархадын аман аялгууг хадгалагч, Хороогийн голын малчидтай уулзаж, тэдний хэл аялгуу, ёс заншил, мал маллах арга ухааны талаар товчхон ярилцаж, амьдрал ахуйтай танилцлаа.

Бид Ренчинлхүмбэ сумын ходон багийн малчин Т. Гантуул хэмээх айл хаврын эхний нүүдэл хийхээр хурлаас тогтож тэднийхийг хөдөлтөл тэндээ 5 хоног байж ойр орчмын Хороогийн гол дагуу айлуудаар орон ажиглалтын болон санамсаргүй бичлэгийн аргаар дархад аман аялгууны онцлогийг тодруулахад гол анхаарлаа хандууллаа. Бид дархад нүүдэллэх уламжлал, аж ахуйн холбогдолтой үг хэллэгийн судалгааг тусад нь судлагдахуун болгохоор зорьсон тул энэ удаагийн өгүүлэлд оруулалгүй орхилоо.

Бид үг бүтээврийн бүрэлдэхүүнд байгаа бүрэлдүүлэгч нэгж авиалбарын утга ялгах шинж түүний үүргийг тодорхойлохдоо ижил бүтэц бүхий үг бүтээврийг чанга сулаар нь эсрэгцүүлэн үзэж хосын зарчмыг баримталлаа.

Ш. Лувсанвандан эгшиг авианы өгүүлэхийн шинж хэлний хэлэгдэх байрыг бус өгүүлэх эрхтний булчин чангарах, сулрах талаас үзэгдлийг анзаарч ангилсан байна. Ингэхдээ “Монгол хэлний эгшиг авиаг хэлэхэд өгүүлэхийн

эрхтний булчин бүх нийтдээ чангарах, сулрах дээр үндэслэж чанга, сул эгшиг бас энэ хоёрын завсрын шинжтэй эгшиг гэсэн гурван бүлэгт хувааж болно. Чанга, сул эгшиг хэлний хойгуур, урдуур хэлэхтэй бүрэн тохирохгүй” [1967: 44] хэмээн тодорхойлсон байна.

Ш. Лувсанвандан “Фонем нь хэлний дохионы тэмдгийн үүрэг гүйцэтгэхэд авианыхаа төрх байдлаар бие биеэсээ ялгарч уул үүргийг гүйцэтгэхээс гадна хоёр, гурав, дөрөв, таваараа хоршиж, тэгэхдээ янз бүрийн дэс дараалалтайгаар хоршиж гүйцэтгэнэ. Фонемуудыг эгшиг, гийгүүлэгч, эр, эр, чанга, сул хэлний, уруулын гэх мэтчилэн авианы төрх байдлаар хялбархан ангилж болдог бол янз бүрээр байрлахыг нь хязгаарлах арга байхгүй” [Лувсанвандан, 2002. Х. 279] хэмээн үзжээ.

Ж. Цолоо Нэг цуваанд дараалан орсон эгшигийн журам, байрлал нь эгшиг авианы эр, эм, уруулын оролцох байдлаар зохицдог учир эгшиг зохицох ёсыг эгшигийн чанга, сулын дараалал, уруулсан дараалал, уужимсан дараалал, ондоошсон дараалал гэж томъёолон [Цолоо, 2008. Х. 91] нэрлэжээ.

Мөн “монгол бичиг зохиолын хэл, халх аялгууны эгшиг авиа нь жирийн богино, огцомшсон богино, урт, хосорхог, урт, чанга, сулаараа дуудагдах зэрэг сонсгол авиа зүйн шинжээрээ тус тус ялгарч үгийн утга бүрдүүлэх үүрэгтэй авиалбар болно гээд халх аялгууны эгшиг авиалбаруудыг ярианы урсгалд үгийн утга ялгах, авиа зааглах зургаан үүрэгтэй” [Цолоо, 2008. Х. 46–4] хэмээн тодорхойлжээ.

С.Мөөмөө монгол хэлний эгшиг фонем ялгаруулах шинжийг дараах байдлаар тав хуваан [Мөөмөө, 1979. Х. 73] үзжээ.

Ж. Санжаа “Дохиожуулах тод байранд байгаа нэг авиалбар нөгөө авиалбартайгаа эсрэгцээд, аль нэг буюу хэсэг шинжээрээ ялгардаг. Үүнийг бид ялгах шинж гэж нэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл нэг авиаг нөгөө авианаас ялгаж байгаа өгүүлэх, сонсох, үүргийн талын шинжийг авианы ялгах шинж [Санжаа, 2018. Х.118] гэнэ” хэмээн үзсэн байна.

Хэлэхэд хэл хатуу тагнай руу өгсөх, уруудах байдлаар эгшигийг уужим (доод өгслийн) -а, дунд е, ү, о уйтан (дээд өгслийн) -i, u, u гэж [Батчулуун, 2016. Х. 70] ангилна. Мөн уужим

эгшигийг нээлттэй, уйтан эгшигийг хаалттай гэж нэрлэх тохиолдол ч бас байна.

Дархад аман аялгууны эгшиг авиалбар түүний бүрэлдэхүүнийг хамгийн анх тодорхойлон үзсэн эрдэмтэн бол Г. Д. Санжеев юм. Тэрээр дархад аман аялгууг а, а', е, е', о, о', и, и' гэсэн найман богино эгшиг авиалбартай хэмээн тодорхойлсон [Санжеев, 1931. Х. 7–11] байна. Гэвч энэ нь дархад аман аялгууны богино эгшиг авиалбарыг бүрэн тодорхойлсон гэсэн үг биш юм.

Дархад аман аялгууны эгшиг авиаг хосын зарчмаар ангилсан эрдэмтдийн ангиллаас Ж. Санжаагийн ангилсан Монгол хэлний эгшиг авианы ялгаруулах зарчимд тулгуурлан ажиглалт хийлээ.

1. Өгүүлэх эрхтний булчингийн чангарал, сулралын байдлаар: **Эр, чанга - Эм, сул**

Бид дархад аман аялгууны богино эгшиг авиаг чанга, хөндий хэлэгдэх байдлаар нь дараах үгсийн эсрэгцүүлэн үзэж богино эгшиг тус бүрийн шинжийг чанга сулаар нь тодорхойлох болно. Ингэхдээ бид монгол хэлний IPA (International Phonetic Alphabet)-ээр галигласан болно.

Чанга: [a], [æ], [æ:], [a:], [ɔ], [œ], [ɔ:], [o], [y], [ə]¹

Сул: [e], [e:], [ə], [ə:], [u]

Эрс: [i], [i:]

Авиалбар гэдэг нь үг, бүтээврийн бүрэлдэхүүнд оролцох үед, бүтээвэр ба үгийн утгыг ялгаруулах хэлний авианы үндсэн гол шинж чанартай. Иймээс дархад аман аялгууны чанга, сул эгшиг авиалбарыг танин ялгахад эгшиг авианы үг бүтээхэд утга ялгаруулах гол шинжээр нь ялган мэдэж болох юм. Жишээлбэл:

Дарх. [axə] – ах, Дарх. [exə] – эх хүн, Дарх. [ixə] – их хэмээх гурван үг нь гурван өөр утгатай боловч бүгдэд нь орсон /x/ авиалбар аль эсвэл үг бүрийн /a/, /e/, /i/ эгшиг авиалбаруудыг хасвал [a], [χ] гэсэн ямар ч утгагүй эгшиг, гийгүүлэгч авиа л үлдэнэ. Тэгэхээр эдгээр үгэнд орсон /a/, /e/, /i/ эгшиг авиалбарууд нь бүтээвэр, үг бүрэлдүүлэхэд утга ялгаруулах гол шинжээ хадгалж байгаа учраас авиалбарын үүрэгтэй эгшиг авиа юм.

Дарх. [oqa:] – уг үндэс, Дарх. [uqæ:] – үгүй гэсэн хоёр үгнээс богино /o/, /u/ эгшиг авиалбарыг эсрэгцэн утга ялгаруулах гол шинжээр нь мэдэж болохын зэрэгцээгээр /a:/, /æ:/ авиалбар байгааг тогтоож болно. Учир нь эхний богино /o/, /u/ авиалбарыг хасвал /qa:/, /qæ:/ гэсэн хоёр өөр утга бүхий үг, бүтээвэр үүсэж байна. Үүнээс /q/ авиаг хасвал /a:/, /æ:/ гэсэн хоёр авиалбартай болох ч эдгээр нь үг, бүтээвэрт утга ялгаруулах шинж чанараа хадгалсаар байна.

Дарх. [etə] > мо.у.з.х. [etɤ:r]

Дарх. [atɔ:] > мо.у.з.х. [ato:]

Дарх. [ɔta:] > мо.у.з.х. [ɔtɔ:]

Дарх. [ota:] > мо.у.з.х. [tæxən]

Дарх. [ite:] > мо.у.з.х. [ite:]

Дарх. [uti:] > мо.у.з.х. [ɔlən] гэх мэт эдгээр зургаан үгс нь зургаан өөр утга бүхий зүйлийг заасан үгс боловч бүгдээрээ болон үг бүрэлдүүлэхэд оролцож байгаа эхний авиалбарууд нь бүгд өөр өөрийн гэсэн үндсэн гол утга ялгаруулах шинжээ хадгалж байна. Эдгээрээс эхний [a], [e], [ɔ], [o], [i], [u] авиаг хасвал үгийн утга тэр чигтээ өөрчлөгдөж [t] нь утгагүй авиа болж бусад нь өөр үг бүтээх [ta:], [te:], [ti:], [tɔ:] гэсэн язгуур бүтээвэр болох ба [t]-г нь дахин хасвал /a:/, /e:/, /i:/ хэмээх урт эгшиг авиалбар үлдэнэ.

Үүнийг ажиглавал дархад аман аялгууны а, е, о, и, у, и' эгшиг авианууд нь өөрийн утга ялгаруулах шинжээ амьд аялгуунаа бүрэн хадгалсаар байгааг илтгэж байна. Мөн /a:/, /e:/, /ɔ:/, /i:/ эдгээр урт эгшиг авиалбарууд ч утга ялгаруулах шинжийг хадгалж байна.

Дарх. [agə] > мо.у.з.х. ар тал, Дарх. [egə] > мо.у.з.х. эрэгтэй хүн. Хэлний чанга, хөндий эгшигийг ялган танихдаа ижил бүтэц бүхий эр, эм эгшигтэй нь үгсийг эсрэгцүүлэн тэдний утга хэрхэн өөр байгаагаар мэдэж болж байна. Жишээлбэл:

Дарх. [agə] > мо.у.з.х. ар тал,

Дарх. [egə] > мо.у.з.х. эрэгтэй хүн гэх хоёр үгийн [a], [e] эгшиг нь авиа эсрэгцэн утга ялгахдаа чанга эгшигтэй үг нь ар тал болон аливаа зүйлийн эсрэг талыг зааж байгаа бол хөндий буюу сул эм эгшигтэй үг нь эр хүн хэмээх хүйсийн харьцааг ялган зааж байна. Мөн уруулын эгшиг авиаг чанга сулын эсрэгцлээр нь авч [o], [u] авиаг харьцуулан үзвэл:

¹ Үгийн тэргүүн бус үед орсон бүх эгшигийг [ə] гэж тэмдэглэнэ.

Дарх. [urə] > мо.у.з.х. үр хүүхэд

Дарх. [orə] > мо.у.з.х. эв дүйтэй, уран хэмээх утгыг зааж байгаа боловч үүний гол агуулга [o], [u] эгшиг авиа нь тус тусын утга ялгах шинжээ бүрэн хадгалж байгаад оршино. Мөн дархад аман аялгууны богино [ɔ], [ə] авиа нь дээрх жишээтэй адил байна. Дархадууд урт эгшигийг халх аялгуутай харьцуулахад уруулын чанга урт эгшиг авиалбар уруулын чанга урт авиалбартайгаа сэлгэж дуудлага өөр боловч ижил утга ялгаруулдаг онцлогтой байна. Жишээлбэл:

Дарх. [ɔ:lə] > мо.у.з.х. [o:lə]

Дарх. [ə:lə] > мо.у.з.х. [u:lə]

Дарх. [tɔ:] > мо.у.з.х. [to:]

Дарх. [tə:] > мо.у.з.х. [tu:]

Дарх. [χɔfɔ:] > мо.у.з.х. [χɔfo:]

Дарх. [χorɔ:] > мо.у.з.х. [χorog:]

гэх мэтээр ярианы хэлэндээ [ɔ:lə] (оола) гэж дуудах боловч тэр нь [o:lə] (уула) гэсэн утгыг л илэрхийлнэ. Мөн [tɔ:] (доо) хэмээн дуудах авч утга зохиолын хэлний [to:] (дуу)-г л зааж байгаа халхын аялгууны уруулын урт чанга эгшигтэй дархадын аялгууны уруулын урт чанга эгшиг зохицдог байна. Харин уруулын урт эм хөндий эгшигтэй уруулын урт хөндий эгшиг зохицдог болохыг дээрх жишээнээс харж болно.

Дархад аман аялгуунд үгийн өргөлтөт үед уруулын эгшиг авиалбар орсон тохиолдолд хойш үедээ уруулын бус урт эгшиг орох үзэгдэл ажиглагдаж байна. Үүнийг халхын аман аялгуутай харьцуулан үзвэл уруулын урт эгшиг уруулын бус урт эгшигтэй эсрэгцэн орж утга ялгаруулахдаа чанга хөндийгөөр зохицож байна.

Дарх. [xəʃe:] > мо.у.з.х. [xəʃə:]

Дарх. [xөгe:] > мо.у.з.х. [xөгə:]

гэх мэт үгсийг дархадууд [xəʃe:], [xөгe:] (хөшээ, хөрээ) гэж ярианы хэлэндээ дуудах боловч урт [e:] (ээ) эгшиг авиалбар нь [ə:] (өө) гэсэн нэг л авиалбарыг зааж байна.

Дархад аман аялгууны эгшиг авиалбарууд нь хоорондоо эр эмээрээ ижилшиж утга ялгахын зэрэгцээ эр эгшиг авианы эм эгшиг авиатай эсрэгцэж утга ялгаж байна. эгшиг зохицох ёсны тухайд зарим нэг тохиолдлыг эс тооцвол монгол хэлний эгшиг зохицох ёсны дагуу авиа авиалбарууд нь бүтээвэрт оролцож өөр өөрсдийн гэсэн үүргээ гүйцэтгэж байна.

2. Хэлний хэвтээ байдлаар: Хэлний урдуурх – хойгуурх

Эгшиг авиаг хэлний байрлалаар буюу хаагуур хэлэгдэж байгаагаар нь хэлний хойгуур, дундуур, урдуур гэж хуваадаг. Хойгуурхыг хэлний угийн эгшиг, түүнээс урагшилж хэлэгдэж байгаа эгшигийг хэлний дунд этгээдээр хэлэгдэх эгшиг гэж үзэж болно.

Урдуур: [ə], [u], [ə:], [ə], [e], [i], [i:]

Жишээлбэл: Дарх. [ə:lə] > мо.у.з.х. [u:lə]

Дарх. [ilsə] > мо.у.з.х. [ilʃʰ]

Дарх. [ʃi:sə] > мо.у.з.х. [ʃe:sə]

Дарх. [əltse:] > мо.у.з.х. [əltsi:]

Дарх. [mөлe:xə] > мо.у.з.х. [mөli:x]

гэх мэт.

Дундуур: [a], [æ], [œ], [ʏ], [a:], [œ:], [ə]

Жишээлбэл: Дарх. [pæro:l] > мо.у.з.х. [pæro:l]

Дарх. [tʰœʏro:] > мо.у.з.х. [tʰɔqro:]

Дарх. [ʏχгəχə] > мо.у.з.х. [oχгəχ]

Дарх. [ɔræ:] > мо.у.з.х. [ɔrɔ:]

Дарх. [pœ:tʰək] > мо.у.з.х. [tœ:tʰək]

Дарх. [emæ:l] > мо.у.з.х. [eme:l]

Хойгуур: [ɔ], [o], [o:]

Жишээлбэл: Дарх. [qatəɣ] > мо.у.з.х. гар нүүр угаах сав

Дарх. [a:ro:l] > мо.у.з.х. [a:ro:l]

Дарх. [qəltso:] > мо.у.з.х. [qəltso:]

3. Хэлний босоо байдлаар: Уужим - уйтан

Хэлний хамгийн доод байрлалд амны хөндийн зай нь хамгийн их болж хэлэгдэх эгшигийг уужим буюу агуу эгшиг гэнэ.

Хэл дунд зэрэг өргөгдөж амны хөндийн зай мөн дунд зэрэг хэлэгдэх эгшгүүд, тэдгээрийн хувилбаруудыг амны хөндийн зайгаар дунд эгшиг гэнэ.

Хэлэхэд хэл хамгийн их өргөгдөж амны хөндийн зай маш бага байх учраас тэдгээрийг явцуу буюу уйтан эгшиг гэнэ.

Уужим: [a], [ə], [æ:]

Жишээлбэл: Дарх. [qatʃək] > мо.у.з.х. [qætʃək]

Дарх. [qæ:хəʏтəχ] > мо.у.з.х.

[qæ:хəʏтəχ]

Дунд: [ɔ], [ə], [e], [ɔ:], [ə:], [œ], [e:]

Жишээлбэл: Дарх. [qərtsəχ] > мо.у.з.х.

[qərtsœ:χ]

Дарх. [kөлөлтсəχ] >

мо.у.з.х. [kөлөлтсəχ]

Дарх. [qəltshɔ:] > мо.у.з.х. [qəltsho:]

Дарх [tʰəʊlɛq] > мо.у.з.х. [tʰəʊlɛk]

Дарх. [nɛxə:lɛx] > мо.у.з.х.
[nɛxu:lɛx]

Уйтган: [i], [u], [i:]

Жишээлбэл: Дарх. [kuntɕe:] > мо.у.з.х.
[kuntɕi:]

Дарх. [niʏfɛxɛ] > мо.у.з.х.
[mo:tɛx] (үнэр орох)

Дарх. [ni:tʰə:lɛx] > мо.у.з.х.
[ni:tʰu:lɛx]

Дарх. [ni:tʰə:] > мо.у.з.х. [ni:tʰu:]

4. Уруулын оролцоогоор : **Уруулын - уруу- лын бус**

Уруул оролцох эсэхээр эгшигийг хоёр хуваана. Уруулаа цорвойж, дугариглаж хэлэх, эгшиг түүний хуулбаруудыг уруулын эгшиг гэж нэрлэнэ. Уруул цорвойхгүй хэлэх эгшгүүд тэдгээрийн хувилбарыг уруулын бус эгшиг гэнэ. Уруулын цорвойлт нь амны хөндийн зайг урт болгох учраас эгшиг авианы өнгөнд чухал үүрэгтэй.

Уруулын эгшиг: [ɔ], [ə], [o], [u], [ɔ:], [ə:], [o:], [œ:]

Жишээлбэл: Дарх. [pɔ:] > мо.у.з.х. [pɔ:]
Дарх. [pə:] > мо.у.з.х. [pu:] (бит-
гий)

Дарх. [tɔre:] > мо.у.з.х. [tɔrə:]

Дарх. [tule:] > мо.у.з.х. [tuli:]

Дарх. [o:tʰə] > мо.у.з.х. [o:tʰ]

Дарх. [χɔrɔ:] > мо.у.з.х. [χɔrɔ:]

Дарх. [ɔ:r] > мо.у.з.х. [o:r]

Дарх. [ə:r] > мо.у.з.х. [u:r]

Уруулын бус эгшиг: [a], [e], [i], [a:], [e:], [i:]

Жишээлбэл: Дарх. [qa:ʏlɛx] > мо.у.з.х.
[χæʏʏrɛx]

Дарх. [niŋgən] > мо.у.з.х. [nimʏən]

Дарх. [ni:lɔ:r] > мо.у.з.х. [ni:lɔ:r]

Дарх. [qatsa:] > мо.у.з.х. [qata:]

Дарх. [newtʰɛrxe:] > мо.у.з.х.
[newtʰɛrxi:]

Дарх. [ɬɛrlɛx] > мо.у.з.х. [ɬawlɛx]

5. Өгүүлэх хугацаагаар: **Урт-богино**

Эгшиг авиаг сонсол зүйн талаас хэлэгдэх хугацаагаар нь урт, богино гэж хоёр хуваана.

Богино: [a], [æ], [ɔ], [œ], [o], [ɣ], [ə], [u], [i], [e]

Жишээлбэл: Дарх. [ətə] > мо.у.з.х. [ət]

Дарх. [ulə] > мо.у.з.х. [χarɛʏtɛxkui]

Дарх. [apə] > мо.у.з.х. [aw] (ан агнах)

Дарх. [ɔlə] > мо.у.з.х. [ɔlɛx]

Дарх. [tsam] > мо.у.з.х. [tsam] (мөр)

Дарх. [erə:] > мо.у.з.х. [eru:]

Дарх. [ərə] > мо.у.з.х. [ər]

Урт: [ɔ:], [ə:], [a:], [æ:], [i:], [e:]

Жишээлбэл: Дарх. [ə:t] > мо.у.з.х. [u:t]

Дарх. [ɔ:lə] > мо.у.з.х. [o:lə]

Дарх. [ə:r] > мо.у.з.х. [u:r]

Дарх. [a:pæ:] > мо.у.з.х. [a:w]

Дарх. [tsa:m] > мо.у.з.х. [tsa:m]

(дээл хувцасны энгэр харааны
уулзвар)

Дарх. [e:rə:] > мо.у.з.х. [e:ru:] (үг
хэлэхдээ ээрч түгдэрдэг хүн)

Дарх. [ɔ:lə] > мо.у.з.х. [o:l]

Дархад аман аялгуунд богино эгшиг урт эгшигтэйгээ эсрэгцэн утга ялгаж, үг бүтээврийг бүрдүүлж байна. Үүнийг ажиглан үзвэл дархад аман аялгуунаа өд хэмээн дуудах үг нь шувууны өдийг зааж байхад өөд хэмээх дуудах үг нь халхын аялгууны үүд нэр үгийг заах юм. Энэ үзэгдэл дархад аман аялгууны богино, урт эгшиг авиалбарын утга ялгах шинж нь тус тусдаа авиалбарын үүрэгтэйг харуулж байна. Мөн урт эгшигийн нөгөө нэг эсрэгцэж байгаа тал дархад аман аялгууны уруулын чанга урт эгшиг халхын аялгууны уруулын чанга урт эгшигтэй эсрэгцэж, хөндий уруулын урт эгшиг хөндийтэй урт эгшигтэй эсрэгцэн утга ялгаж байна.

Бүтцээр: **Ерийн - хос**

Эгшигийг дан нэг эгшиг, эсвэл хоёр өөр эгшгээс бүтсэн эсэхээс шалтгаалж бүтцээр нь энгийн эгшиг, хос эгшиг гэж хоёр ангилж болно. Харин дархад аман аялгууны эгшиг авиалбарыг бүтцээр нь *ерийн эгшиг, хос эгшиг, хосорхог эгшиг* гэж гурав ангилж болохоор байна.

Ерийн эгшиг: [a], [ɔ], [o], [ə], [u], [e], [i], [a:], [e:], [ɔ:], [ə:], [i:]

Жишээлбэл: Дарх. [qayno:lɛxə] > мо.у.з.х.

[qayno:lɛx]

Дарх. [pɔga:] > мо.у.з.х. хавирганы
толгойны толь

Дарх. [kinʏlɔ:lɛx] > мо.у.з.х.

[kinʏlu:lɛx]

Дарх. [kuptɛx] > мо.у.з.х. [kəwtɛx]
(цохих)

Дарх. [qɔmta:χ] > мо.у.з.х.

[qɔmtɔ:χ]

Дарх. [ni:tʰə:l] > мо.у.з.х.

[ni:tʰu:l]

Дарх. [teɪtʃe:] > мо.у.з.х. [teɪtʃe:]

Хос эгшиг: [œ:]

Жишээлбэл: Дарх. [pœ:tʰək] > мо.у.з.х.

[pœ:tʰək]

Дарх. [œ:rəʈsʰɔ:] > мо.у.з.х.

[œ:rəʈsʰɔ:]

Хосорхог урт эгшиг: [y:], [y:], [æ:], [e:], [ø:], [œ:]

Дарх. [y:lə] > мо.у.з.х. [uilə]

Дарх. [y:ləxə] > мо.у.з.х. [oiləx]

Дарх. [æ:l] > мо.у.з.х. [æ:l]

7. Сонгол зүйн талаас: **Өргөлттэй - Балархай**

Булчингийн чангарал нь хийн урсгалыг хүчтэй гаргах буюу дууг өндөрсгөн шингэрүүлэхтэй, мөн ямар нэгэн үеийг бусдаас онцлон өгүүлэхтэй холбоотой.

Ерөнхийдөө үгийн тэргүүн үеийн эгшиг бусдаасаа илүү өргөлттэй, харин тэргүүн бус битүү үеийн үед орсон богино эгшиг балархай, үе, үгийн төгсгөлийн задгай үед орсон богино эгшиг огцом хэт балархай сонсогдоно. Ийм богино эгшигийг өргөлттөд тод, өргөлтгүй заримдаг балархай, огцом хэт балархай эгшиг гэж ангилна.

Дархадын аман аялгуунд өргөлттөд үед /a/, /æ/, /e/, /i/, /ɔ/, /œ/, /ə/, /u/, /o/, /y/ эдгээр арван эгшиг авиалбар чанга хөндийгөөр зохицон оролцож байна.

Харин балархай эгшигт /ə/4 (а, е, о, ө) эдгээр эгшиг авиалбарууд орж байна.

Жишээлбэл: Дарх. [qɑyno:ləx] > мо.у.з.х.

[qɑyno:ləx]

Дарх. [pɔrɑ:] > мо.у.з.х. хавирганы толгойны тал

Дарх. [kɪntʃlɔ:ləx] > мо.у.з.х.

[kɪntʃlu:ləx]

Дарх. [kuptəx] > мо.у.з.х. [kəwtəx] (цохих)

Дарх. [pæɣɔ:l] > мо.у.з.х. [pæɣo:l] бариул

Дарх. [tʰɔyɣɔ:] > мо.у.з.х. [tʰɔqɣɔ:]

Дарх. [yɣɣəx] > мо.у.з.х. [oɣɣəx]

Дарх. [ɔɣæ:] > мо.у.з.х. [ɔɣɔ:]

Дарх. [pœ:tʰək] > мо.у.з.х.

[pœ:tʰək]

Дарх. [emæ:l] > мо.у.з.х. [eme:l]

8. Хамрын оролцоогоор: **Хамаршсан - Эс хамаршсан**

Халх аялгууг судалсан Г.И.Рамстедт үгийн эцэст тохиолддог хамарсан η гийгүүлэгч өмнөх эгшигээ хамаршуулж улмаар хамаршсан гийгүүлэгч зарим тохиолдолд гээгдэж хамаршсан эгшиг нь хамрын авиалбарын үүрэгтэй [Рамстедт, 1967: 142–143] болжээ. Харин монгол хэлэнд хамрын эгшиг авиалбар байхгүй, зөвхөн зэргэлдээх хамрын гийгүүлэгчийн нөлөөгөөр хамаршсан хувилбартай болно.

Дарх. [ningəŋ] > мо.у.з.х. [nimgəŋ]

Бид дархадын салбар аман аялгууны эгшиг авиалбар түүний бүрэлдэхүүний тухайд эрдэмтдийн дэвшүүлсэн санал өөрийн ажигласан ажиглалт дээр үндэслэн, эгшиг авиалбарын утга ялгаруулах шинжээр нь эсрэгцүүлэн үзэж /a/, /æ/, /e/, /ə/, /o/, /y/, /ɔ/, /œ/, /u/, /i/ гэсэн арван богино эгшиг авиалбарыг тогтоосноос гадна /a:/, /e:/, /ɔ:/, /ə:/, /i:/ гэсэн таван урт эгшиг авиалбар, /o:/, /u:/, /æ:/, /e:/, /ə:/, /ɔ:/ гэсэн зургаан хосорхог урт эгшиг авиалбар бүхий /œ:/ гэсэн нэг хос эгшиг авиалбартай хэмээн үзлээ.

Дархад аман аялгуунд уруулын бус чанга эгшиг уруулын бус чанга эгшигтэйгээ зохицохоос гадна уруулын чанга эгшигтэй зохицон орж байна.

Уруулын бус хөндий эм эгшиг уруулын бус сул эм эгшигтэйгээ зохицохын зэрэгцээгээр уруулын сул эм эгшигтэй цувран зохицож дараалан орж байна.

Уруулын эгшиг уруулын эгшигтэйгээ зохицон орохоос гадна уруулын бус эгшигтэй чанга хөндийгөөрөө зохицон орж дараах үеийнхээ эгшиг авиалбарыг уруулуулж байна.

Дархад аман аялгуунд балархай эгшиг нь уруулын эгшигтэй үгийн сүүлчийн үед уруулын бус чанга эгшиг орсон тохиолдолд балархайших үзэгдэл ажиглагддаггүй тод дуудагддаг.

Мөн дархадын аман аялгуунд уруулын эгшиг нь уруулын бус эгшигтэйгээ эсрэгцэн утга ялгахаас гадна уруулын эгшиг нь их уужимшиж хэллэгддэгийн дээр тэргүүн үеэс хойш орсон урт эгшиг ямагт өргөлттөд үедээ татагдан дуудагддаг.

Орчин цагийн монгол хэлний авиа зүйн нэгэн сонирхолтой үзэгдэл бол авиа зохицох ёс юм. Энэ үзэгдлийн гол шинж чанар нь үгийн

бүрэлдэхүүнд орсон бүх энгийн эгшигийг захиран зохицуулахад оршино. Авиа зохицох ёс нь монгол хэлэнд үг бүтээх, хувилгах чухал хэрэглүүрийн үүрэгтэй болдог. Ийм ч учраас авианы зохицол нь гийгүүлэгч гэх авиа зүйгээр хүрээлэгдэх бус хэлний гүн бүтцийг хамрах хэлний хэв шинжийн бүтцийн зангилаа болж өгдөг.

“Хэлэхэд илрэх авиа нь гинжин урсгал мэт цувран гардаг. Ярианы урсгалд нэг авианы төгсгөлийг дараагийн авианы эхлэлтэй бараг давхиулан өгүүлдгээс гадна, авианы хувьсал нь авианы үгэнд тохиолдох байр, авиа авиатайгаа хэрхэн шүтэн барилдах, өгүүлж дуудахын чанга сул, өндөр нам, хурд, өргөлт, аялга зэрэг олон зүйлээс шалтгаалдаг [Пүрэвжав, 2020. Х. 68] билээ”.

Монгол хэлний авиа зохицох ёс нь хэл шинжлэлийн томоохон үүргийг гүйцэтгэдэг нэгэн төрлийн тогтолцоо бүхий, хэл яриа, бичиг зохиолын хууль юм.

Халх аялгууны нэгэн адилаар дархад аман аялгууны чанга, сул эгшигийн зохицол нь эгшиг зохицох ёсыг бүрэн гүйцэд дагадаг эсэхийг ажиглан үзвэл дараах байдалтай байна.

Дархад аман аялгуунд уруулын бус чанга эгшиг уруулын бус чанга эгшигтэйгээ зохицохоос гадна уруулын чанга эгшигтэй зохицон орж байна.

Уруулын бус хөндий эм эгшиг уруулын бус хөндий эм эгшигтэйгээ зохицохын зэрэгцээгээр хөндийн уруулын эм эгшигтэй цувран зохицож дараалан орж байна.

Уруулын эгшиг уруулын эгшигтэйгээ зохицон орохоос гадна уруулын бус эгшигтэй чанга хөндийгөөрөө зохицон орж, дараах үеийнхээ эгшиг авиалбарыг уруулшуулж байна.

Дархад аман аялгуу нь монгол хэлний зүй тогтол ерөнхий бүтэцтэй нийлдэг ч зарим тохиолдолд монгол хэлний эгшиг зохицох ёсыг зөрчих үзэгдэл ажиглагдаж байна.

Жишээлбэл: Дарх. [xegæ:] > мо.у.з.х. [xegɛ:]

Дарх. [ɛrɣæ:] > мо.у.з.х. [ɛrɣi:]

Дарх. [emæ:ɪ] > мо.у.з.х. [eme:ɪ]

Дарх. [eʏæ:] > мо.у.з.х. [ix]

(хамгийн их)

Дарх. [ɛptʰæ:] > мо.у.з.х. [ɛftʰe:]

Дарх. [ɛrɣʃæ:] > мо.у.з.х. асуух үг ирэх гэж байна уу гэсэн утгатай.

Уруулын бус хөндий эгшигтэй үгсийн араас чанга хосорхог урт эгшиг авиаг залган хэлж байгаа үзэгдэл нь үндсэн үгийнхээ утгыг хадгалж байгаа ч орчин цагийн монгол хэлний эгшиг зохицох ёсыг зөрчин хэлэгдэж байна.

Дарх. [tʰulæ:] > мо.у.з.х. [tʰule:]

Дарх. [tɔræ:] > мо.у.з.х. [tɔrɛ:]

Дарх. [emənæ:] > мо.у.з.х. [ɔmən]

Дарх. [ɔʏyæ:] > мо.у.з.х. [ɔʏyɛx]

Дарх. [ɔ:tæ:] > мо.у.з.х. [ɔ:tɔ:]

Уруулын хөндий эгшигийн араас уруулын бус эр чанга хосорхог урт эгшиг /æ:/ авиалбарыг залгаж байна. Мөн уруулын чанга эгшигийн араас уруулын бус хөндий эгшигийг залган хэлэх үзэгдэл ч дархад аман аялгууны хэлэгдэж байгаа нь сонирхолтой зүй тогтол хэмээн хэлж болохоор байна. Энэ үзэгдэл нь эгшигийн тагнайших үзэгдэлтэй холбоотой гэж болохоор байна.

Дарх. [pʏyɛ:] > мо.у.з.х. [qwæ:] (хүндэтгэсэн үг)

Дарх. [pɔlɛ:] > мо.у.з.х. [pɔlæ:]

Дарх. [tɔyɛ:lɔŋ] > мо.у.з.х. [tɔyɔiɔŋ]

Энэхүү үзэгдэл нь гол төлөв эм үгэнд тохиолдохдоо орчин цагийн монгол хэлний урт эгшигийн байранд аль эсвэл хос эгшиг авиалбарын байранд илэрч байна.

Эдгээр үзэгдэл гол төлөв хэл тагнайн, хамжих g, ɣ, n гурван гийгүүлэгч¹, хэл шүдний хамжих d, t² болон чичрэх r³ гийгүүлэгч орсон үгэнд гол төлөв эгшиг зохицох ёсыг зөрчиж байна.

Дархадын аман аялгуунд эгшиг авиа дэвшин ижилшихээсээ илүү ухран ижилших үзэгдэл түгээмэл ажиглагдахын зэрэгцээ эгшиг авиа ондооших үзэгдэл нэлээд байна. Эгшиг зохицох ёсны дагуу эр эмийн зохицол байгаа хэдий ч эгшиг зохицох ёсноос ангид түүний зөрчихсөн дуудлага бүхий үгс цөөнгүй байна. Энэ нь

¹ Монгол хэлний g, ɣ, n гурван гийгүүлэгч авиаг хэлэхэд хэл агшиж, булчин нь чангарч тагнай хойд хэсэг, нармайтай хамжсанаа уушгинаас ирсэн хийн түрлэг гадагшлахдаа хүчтэй дэлбэрэн алгуур үргэлжлэн гардаг. Мөн амны хөндийн зай уйтан болж хамрын хөндий уг авианы дуудлагад нэмэлт өнгө [Цолоо, 2008. Х. 98] үүсгэнэ.

² Энэ хоёр гийгүүлэгчийн бүтэх байр адилавар боловч гарах дууны чанга сул харилцан эсрэгцэлдэж [Цолоо, 2008. Х. 99] байна.

³ Монгол хэлний r гийгүүлэгчийг хэлэхэд хэлний үзүүр хэсэг түүш доргиж чичирдэг шинжээр нь чичрэх гийгүүлэгч гэж [Цолоо, 2008. Х. 100] нэрлэдэг.

гол төлөв тагнайшсан холбоотойгоор үгийн дуудлага өнгө өөрчлөгдөж байгаагийн нэг хэлбэр бөгөөд дархадууд зарим үгсийг тагнайн гийгүүлэгчийн нөлөөгөөр ихэд тагнайшуулан дууддаг хэмээн хэлж болох юм.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн үеийн эрдэмтдийн сурвалжилан тэмдэглэсэн хээрийн шинжилгээний ангийн тайлан бүтээлийг нэгтгэн дүгнэх тэдний хийсэн бүтээснийг цааш улам баяжуулан судлах хувьсал өөрчлөлтийг цаг алдалгүй нээн илрүүлэх цаг нэгэнт иржээ.

Нутгийн аялгуу нь тухайн ард түмний түүх соёлыг тээн хадгалж байдаг өвөрмөц онцлогтой бөгөөд тухайн хэлэлцэгчдийн нийгэм соёлын өөрчлөлтийн тусгал улиран өнгөрсөн он

жилүүдийн түүхэн ул мөрийг агуулж гэрчлэх хэрэглэгдэхүүн болж үлддэг. Нутгийн аман аялгууг нийгмийн хэрэглээний төвшинд хэрэглээ хийгээд нийгэм хэл шинжлэлийн талаас нь авч үзэж болохоор байна.

Бид дархад аман аялгууны монгол хэл аялгуунд эзлэх байр, түүний хувьслыг цаашид нарийн тодорхойлох шаардлагатай болж байна.

Нутаг нутгийн аман аялгуугаар хэлэлцэгчдийн өвөрмөц аялгуу нь нийгэм цаг үеэ даган хувьсан өөрчлөгддөг тул өнөө цагт дахин өнгөрсөнтэйн харгуулан зэрэгцүүлэн авч үзэхийн зэрэгцээгээр төв аялгуунаа хэрхэн нэвтэрч байгааг ажиглан үзэж, цуваа цагийн үүднээс тусгайлан авиа зүйн судалгааг хийвэл нэн сонирхолтой байна гэдэгт бүрнээ итгэлтэй байна.

НОМ ЗҮЙ

Батчулуун, 2016: Батчулуун Д. Хэл шинжлэлийн удиртгал. Уб., 2016.

Batchuluun D. Kel shinjleliin udirtgal [Introduction to Linguistics]. Ulaanbaatar, 2016.

Баярчимэг, 2018: Баярчимэг Э. Буриад хэл-аялгууны талаарх судалгааны бүтээлүүдийг танилцуулах нь //Буриад судлал VII, Уб., 2018.

Bayarchimeg E. Buriad khel ayalguunii talaarx sudalgaanii buteeluudiig tanilcuulah ni// Buriad sudlal [Introduction to study of Buryat dialect// Study of Buryat] VII, Ulaanbaatar, 2018.

Болд, 2006: Болд Л. Монгол хэл шинжлэлийн асуудалд. Уб., 2006.

Bold L. Mongol khel shinjleliin asuudal [On the Question of Mongolian Linguistics]. Ulaanbaatar, 2006.

Вандуй, 2016: Вандуй Э. Халхын дорнод дэд аман аялгуу// Монгол судлал. Tomus VI, Fasc 15–21. Уб., 1967. 3–17 х.

Vandui E. Khalkhiin dornod ded aylguu // Mongol sudlal [Eastern Second Dialect of the Khalkha Dialect // Mongolian study]/ Tomus VI, Fasc 15-21. Ulaanbaatar, 1967. 3–17 pp.

Гантогтох, 2018: Гантогтох Г. Монгол хэл, аялгуу үсэг бичгийн чуулган. Уб., 2018.

Gantogtokh G. Mongol khel, aylguu useg bichgiin chuulgan [Collection of Mongolian Language, Dialects and Letters]. Ulaanbaatar, 2018.

Лувсанвандан, 1967: Лувсанвандан Ш. Монгол хэлний эгшгийн байрлал ба өргөлт// Монгол судлал. Tomus VI, Fasc 9-14. Уб., 1967. 3-10 х.

Lusvanvandan Sh. Mongol khelnii egshgiin bairlal ba urgult // Mongol sudlal [Position and Stress of

Mongolian Vowels // Mongolian Studies]. Tomus VI, Fasc 9–14. Уб., 1967. P. 3–10.

Мөөмөө, 1979: Мөөмөө С. Монгол хэлний авиан зүй. Уб., 1979.

Muumuu S. Mongol khelnii avian dsui [Phonetics of Mongolian]. Ulaanbaatar, 1979.

Пүрэвжав, 2020: Пүрэвжав Э. Монгол хэлний хэмжээ. Уб., 2020.

Purevjav E. Mongol khelnii khem khemjee [Mongolian Language Norm]. Ulaanbaatar, 2020.

Санжаа Ж., Надмид Ж, 2018: Санжаа Ж, Надмид Ж. Монгол хэлний авиа зүй ба авиалбар зүй. Уб., 2018.

Sanjaa J. Nadmid J. Mongol khelnii avia zui ba avialbar zui [Phonetics and Phonology of Mongolian]. Ulaanbaatar, 2018.

Санжеев, 1931: Санжеев Г.Д. Дархадын аман аялгуу ба аман зохиол. Л., 1931. 7–11х.

Sanjeev G.D. Darkhadiin aman ayalguu ba aman zokhiol [Darkhat Dialect and Folklore]. L., 1931. 7–11 pp.

Төмөртоого, 1967: Төмөртоого Д. Дархад аман аялгууны урт эгшиг тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл// Хэл зохиол. 4-р боть, 1-4-р дэвтэр. Уб., 1967.

Tumurtogoo D. Darkhad aman ayalguunii urt egshig medgeeriin uusliin tukhai товч temdegel // Khel zokhiol [Essays on Long Vowels of the Darkhat Dialect and Their Origin // Linguistics and Literary]. Tomus IV, Fasc. I-IV. Ulaanbaatar, 1967.

Туяа, 2011: Туяа Д. Дархадын салбар аман аялгууны онцлог. Уб., 2011.

Tuya D. Darkhadiin salbar aman ayalguunii ontslog. [Peculiarities of the Darkhat Dialect Groups]. Ulaanbaatar, 2011.

Цолоо, 2011: Цолоо Ж. Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. Уб., 2011.

Tsoloo J. Orchin tsagiin mongol khelnii nutgiin ayalguu [Dialects of Modern Mongolian]. Ulaanbaatar, 2011.

Цолоо, 2008: Цолоо Ж. Орчин цагийн монгол хэлний авиа зүй. Уб., 2008.

Tsoloo J. Orchin tsagiin mongol khelnii avia zui [Phonetics of Modern Mongolian]. Ulaanbaatar, 2018.

Лувсанвандан, 2002: Лувсанвандан Ш. Монгол хэлний авиа зүйн онол практикийн асуудлууд. Эмхтгэн, өмнөх үг бичсэн Ж.Санжаа. Уб., 2002. 374 х.

Luvsanvandan Sh. Mongol khelnii avia zuin onol praktikiin asuudluud [On the Question teory of practic Mongolian Linguistics]. Ulaanbaatar, 2002.

Шадавын Лувсанвандан Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. IV боть. Монгол хэлний авиа, үсэг бичгийн судлал. Эрхлэн хэвлүүлсэн Б. Түвшинтөгс. Уб., 2019.

Shadaviin Luvsanvandan Erdem shinjilgeenii bu-teeliin chuulgan. IV boti. Mongol khelnii avia, useg bichgiin sudlal. Erkhlen khevluulsen B. Tuvshintugs [Shadaviin Luvsanvandan Collection of Scientific Papers. Tomus IV. Study on Mongolian Phonetics and Letters]. Ulaanbaatar, 2019.

Шадавын Лувсанвандан Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. III боть. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Эрхлэн хэвлүүлсэн Б. Түвшинтөгс. Уб., 2019.

Shadaviin Luvsanvandan Erdem shinjilgeenii bu-teeliin chuulgan. IV boti. Mongol khelnii avia, useg bichgiin sudlal. Erkhlen khevluulsen B. Tuvshintugs [Shadaviin Luvsanvandan Collection of Scientific Papers, Tomus III, Structure of Modern Mongolian]. Ulaanbaatar, 2019.

Шархүү, 1984: Шархүү Ц. Дархадын аман аялгууны урт эгшигийн тухай. МУИС, ЭШБ, УБ., 1984. 133–139 х.

Sharkhuu Ts. Darkhad aman ayalguunii urt egshgiin tukhai [On the Long Vowels of the Darkhat Dialect]. Scientific collection of the National University of Mongolia. Ulaanbaatar, 1984. 133–139 pp.

Рамстедт, 1967: Рамстедт Г.И. Монгол бичгийн хэл ба өргөөгийн халх аман аялгууны харьцуулсан авиа зүй. Орчуулсан Г. Лувсанцэрэн. Хэл зохиол. 4-р боть, I-IV. Уб., 1967.

Ramstedt G.I. Mongol bichgiin khel ba urguugiin khalkh aman ayalguunii kharitsuulsan avia zui. [Comparative phonetics of the Mongolian written language and the Khalkha-Urga dialect]. Translated G.Luvsantseren. Linguitics and Literary. Tomus IV. Fasc. I-IV. Ulaanbaatar, 1967.

СИСТЕМА ГЛАСНЫХ ФОНЕМ ДАРХАТСКОГО ДИАЛЕКТА

Мөнхбатын Очирцэнд

Институт языка и литературы Монгольской академии наук

Диалектология является предметом систематического знания родного языка, а также играет важную роль в формировании основных диалектов литературных языков. В настоящее время существует несколько областей исследований для изучения местных диалектов в соответствии с социолингвистикой, этнологией и региональной лингвистикой. В настоящее время дархаты представляют собой в этническом плане три крупные группы населения. В XIII в произошло смешение кочевых тувинцев с лесными жителями, позже их потомки смешались с хотогойтами и некоторыми ойратами. Это обстоятельство дает возможность использовать языковые особенности и лексику дархатов при изучении средне-и-древнемонгольского языка. По словам носителей дархатского диалекта, дархаты сомонов Улан-Уул и Ренчинлхумбе узнают друг друга по особенностям речи. Присутствуют некоторые различия также в отраслевых диалектах.

Ключевые слова: бинарный принцип, локальный говор или диалект, дархатский говор, гласные фонемы

Об авторе: Очирцэнд Мөнхбатын, младший научный сотрудник, Институт языка и литературы МАН (Улан-Батор, Монголия) (ochirtsend_m@mas.ac.mn).

THE SYSTEM OF VOWEL PHONEMES OF THE DARKHAT DIALECT

Munkhbatyn OCHIRTSEND

Institute of Language and Literature. Mongolian Academy of Sciences

Dialectology is a subject of systematic knowledge of the mother tongue, and also plays an important role in establishing the basic dialects of literary languages. In modern days there are many research fields to study local dialects according to sociolinguistics, ethnology, and regional linguistics. The Darkhad people have evolved into three large-scale “population flows” throughout history, and can now be considered to be among three different local dialects. Historically, the 13th-century forest dwellers and nomadic Tuvans were mixed with their descendants, as well as the Khotgoids, and some Oirats. From this, it is possible to determine the traces and features of the Middle and ancient Mongolian language from the linguistic features and vocabulary of the Darkhads. According to the Darkhad dialect speakers, the Darkhads of Ulaan-Uul and Renchinlkhumbe soums know each other by their speech features, and there is a slight difference in branch dialects.

Key words: Binary principle, semantic distinction, vowel phoneme, Darkhad dialect

About the author: **OCHIRTSEND Munkhbatyn**, Master. Sc. (Philology), Researcher, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (ochirtsend_m@mas.ac.mn).